МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Сүхбаатарын ЭРДЭНЭБОЛД

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 27 07, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: erdenebold@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.10.26 № УИХ-03/11937

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА САНДАГИЙН БЯМБАЦОГТ
ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай” анхдагч хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН С.ЭРДЭНЭБОЛД

Ж.АЛДАРЖАВХЛАН

О.АЛТАНГЭРЭЛ

Н.АЛТАНХУЯГ

Н.АЛТАНШАГАЙ

Д.АМАРБАЯСГАЛАН

С.АМАРСАЙХАН

О.АМГАЛАНБААТАР

0000000388

Ч.АНАР

А.АРИУНЗАЯА

Т.АУБАКИР

Х.БААСАНЖАРГАЛ

Ц.БААТАРХҮҮ

М.БАДАМСҮРЭН

Э.БАТ-АМГАЛАН

Б.БАТБААТАР

Д.БАТБАЯР

Р.БАТБОЛД

Ж.БАТЖАРГАЛ

Д.БАТЛУТ

О.БАТНАЙРАМДАЛ

Ж.БАТСУУРЬ

Н.БАТСҮМБЭРЭЛ

Х.БАТТУЛГА

Б.БАТЦЭЦЭГ


П.БАТЧИМЭГ

Э.БАТШУГАР

Б.БАТ-ЭРДЭНЭ

Ж.БАТ-ЭРДЭНЭ

0000000388



Б.БАЯРБААТАР

Ж.БАЯРМАА

Ж.БАЯСГАЛАН

Б.БЕЙСЕН

Х.БОЛОРМАА

Э.БОЛОРМАА

Х.БУЛГАНТУЯА

Д.БУМ-ОЧИР

Ш.БЯМБАСҮРЭН

С.БЯМБАЦОГТ

Ж.ГАЛБАДРАХ

А.ГАНБААТАР

Г.ГАНБААТАР

Ж.ГАНБААТАР

С.ГАНБААТАР

Д.ГАНБАТ

П.ГАНЗОРИГ

Д.ГАНМАА

Л.ГАНТӨМӨР

Х.ГАНХУЯГ

М.ГАНХҮЛЭГ

0000000388

Ц.ДАВААСҮРЭН

Г.ДАМДИННЯМ

Т.ДОРЖХАНД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Б.ЖАВХЛАН

Х.ЖАНГАБЫЛ

Б.ЖАРГАЛАН

Д.ЖАРГАЛСАЙХАН



С.ЗАМИРА

Б.ЗАЯАБАЛ

Ж.ЗОЛЖАРГАЛ

С.ЗУЛПХАР

Ц.ИДЭРБАТ

Ч.ЛОДОЙСАМБУУ

Г.ЛУВСАНЖАМЦ

С.ЛҮНДЭГ

М.МАНДХАЙ



Л.МӨНХБААТАР

Ц.МӨНХБАТ

Л.МӨНХБАЯСГАЛАН

Т.МӨНХСАЙХАН

0000000388

Б.МӨНХСОЁЛ

П.МӨНХТУЛГА

Ц.МӨНХТУЯА

З.МЭНДСАЙХАН

Б.НАЙДАЛАА

Н.НАРАНБААТАР

П.НАРАНБАЯР

М.НАРАНТУЯА-НАРА

Ч.НОМИН

О.НОМИНЧИМЭГ

Н.НОМТОЙБАЯР

Э.ОДБАЯР

С.ОДОНТУЯА

У.ОТГОНБАЯР

Г.ОЧИРБАТ

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ПУНСАЛМАА

Д.ПҮРЭВДАВАА

Б.ПҮРЭВДОРЖ

Д.РЭГДЭЛ

П.САЙНЗОРИГ

0000000388

Ц.САНДАГ-ОЧИР

О.САРАНЧУЛУУН

М.САРНАЙ

Л.СОРОНЗОНБОЛД

Р.СЭДДОРЖ

Ц.ТУВААН

Б.ТУЛГА

Б.ТҮВШИН

Х.ТЭМҮҮЖИН

Г.ТЭМҮҮЛЭН

А.УНДРАА

Ч.УНДРАМ

Н.УЧРАЛ

Б.УЯНГА

Г.УЯНГАХИШИГ

Д.ҮҮРИЙНТУЯА

Г.ХОСБАЯР

Б.ХЭРЛЭН

Д.ЦОГТБААТАР

ДА.ЦОГТБААТАР

О.ЦОГТГЭРЭЛ

0000000388



С.ЦЭНГҮҮН

Ж.ЧИНБҮРЭН

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Ө.ШИЖИР

Л.ЭНХ-АМГАЛАН

Б.ЭНХБАЯР

Ж.ЭНХБАЯР

Л.ЭНХНАСАН

Д.ЭНХТУЯА

Д.ЭНХТҮВШИН

М.ЭНХЦЭЦЭГ

С.ЭРДЭНЭБАТ

Р.ЭРДЭНЭБҮРЭН

0000000388

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Сүхбаатарын ЭРДЭНЭБОЛД

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-07, Факс: 32-70-16
E-mail: erdenebold@parliament.mn
http://www.parliament.mn

2026.10.01 № УИХ-03/10774

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлын зарим гишүүдтэй хамтран "Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай" анхдагч хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу тус хуулийн төслийг хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга болон холбогдох баримт бичгүүдийг хавсаргав.

Хавсралт 95. хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН С.ЭРДЭНЭБОЛД

ТУС3764 9023051393 9087184

0000000372

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.06.16 № ХЗГ/2125

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН
С.ЭРДЭНЭБОЛД ТАНАА

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулж Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай хууль /Анхдагч хууль/-ийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хавсралт 04 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХБАЯР

000265007075

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар хуралдааны тэмдэглэлд:

"3.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос санаачлан боловсруулсан Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай анхдагч хуулийн төсөлд өгөх Засгийн газрын санал, дүгнэлт

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос санаачлан боловсруулсан Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай анхдагч хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд дараах үндэслэлээр хуулийн төслийг дэмжих боломжгүй тухай саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтад ""давхар даатгалын компани" гэж энэ хуулийн дагуу тариалангийн индексжүүлсэн даатгалын давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай чиг үүрэг бүхий хуулийн этгээд" гэж тодорхойлсон бөгөөд төслийн 17, 18, 19, 20 дугаар зүйлд тус тус тусгасан сан, удирдлага, зохион байгуулалт зэрэг зохицуулалтаар тариалангийн индексжүүлсэн даатгалын чиглэлээр бие даасан тогтолцоог бий болгохоор байгаа боловч тухайн институтийн эрх зүйн статус, одоо үйлчилж буй давхар даатгалын тогтолцоотой хэрхэн уялдах нь тодорхойгүй байна;

2.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.14, 4.1.15, 4.1.16 дахь заалтад "хамтын эрсдэлийн сан", "эрсдэлийн дунд түвшний сан", "эрсдэлийн дээд түвшний сан" гэж тус тус тодорхойлсон боловч төслийн 19 дүгээр зүйлд "дунд түвшний эрсдэлээс хамгаалах сан", "дээд түвшний эрсдэлээс хамгаалах сан" гэж ялгаатай нэршил хэрэглэсэн нь нэр томьёоны нэгдмэл байдлыг алдагдуулж, сангуудын эрх зүйн статус, зориулалт, хөрөнгийн эх үүсвэр, төлбөрийн дарааллын ялгааг ойлгож хэрэглэхэд хүндрэл үүсгэхээр байна. Түүнчлэн, төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтад "даатгалын нэгж" гэж, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт "даатгалын хамрах нэгж" гэж мөн ялгаатай нэршил хэрэглэсэн нь хууль хэрэглээний нэгдмэл байдалд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтад Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх, 30.1.3 дахь заалтад үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичихээр заасан нийтлэг шаардлагад нийцүүлэх;

3.Хуулийн төслийн 23 дугаар зүйлд төрөөс даатгалын хураамжид татаас олгох, дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг тусгасан байна. Тухайлбал, мөн зүйлийн 23.1 дэх хэсэгт даатгалын хураамжийн тодорхой хувийг татаас хэлбэрээр төрөөс санхүүжүүлэх, 23.2 дахь хэсэгт татаасын хувь хэмжээ, хамрах хүрээ, зорилтот бүлгийг Засгийн газар батлахаар, 23.4 дэх хэсэгт индексжүүлсэн даатгалд

хамрагдсан тариаланчдыг төрөөс олгох бусад дэмжлэг, урамшуулалд нэн тэргүүнд хамруулахаар тусгасан боловч санхүүжилтийн эх үүсвэр, улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, төрөөс хүлээх санхүүгийн үүргийн дээд хэмжээ, хэрэгжилтийн үе шат тодорхойгүй байна.

Иймд төрийн дэмжлэг, татаастай холбоотой зохицуулалтыг төсвийн бодит боломж, санхүүжилтийн эх үүсвэр, зорилтот бүлэг, хэрэгжилтийн үе шат, төрөөс хүлээх үүргийн дээд хязгаартай уялдуулан дахин боловсруулах шаардлагатай;

4.Хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт индекс тооцоход ашиглах цаг уурын ажиглалтын сүлжээ, зайнаас тандан судлалын мэдээлэл, ургацын статистикийн чанар, хүртээмжийг төрөөс дэмжихээр тусгасан боловч дэмжлэгийн санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгө оруулалтын хэмжээ, ашиглалтын болон засвар үйлчилгээний зардал, хэрэгжүүлэх байгууллагын чиг үүрэг тодорхойгүй байх тул төрийн дэмжлэг, татаас, эрсдэлийн сангийн зохицуулалтыг төсвийн бодит боломж, санхүүжилтийн тодорхой эх үүсвэр, хэрэгжилтийн үе шат, байгууллагуудын чиг үүрэгтэй уялдуулан дахин нягтлах нь зүйтэй;

5.Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1-6.1.4 дэх заалтад хур тунадас, температур, хөрсний чийг, зайнаас тандан судлал, сумын дундаж үзүүлэлт зэрэг индексийн төрөл, техникийн аргачлалыг нарийвчлан тогтоохоор тусгажээ. Индексийн төрөл, өгөгдлийн эх үүсвэр, техникийн аргачлал нь шинжлэх ухаан, технологийн хөгжлөөс хамааран өөрчлөгдөх боломжтой бөгөөд зохицуулалтын уян хатан байдлыг хязгаарлах эрсдэлтэй тул хуулиар үндсэн зарчим, шаардлагыг тогтоож, харин индексийн аргачлал, техникийн стандарт, актуар тооцоолол зэрэг нарийвчилсан асуудлыг холбогдох мэргэжлийн стандарт, гэрээний нөхцөлөөр зохицуулах нь зүйтэй байна;

6.Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт индексийн тооцоонд ашиглах мэдээллийн эх үүсвэрийг тусгахдаа 8.2.2 дахь заалтад “мэдрэгч төхөөрөмжийн мэдээлэл”, 8.2.4 дэх заалтад “зайнаас тандан судлал, хиймэл дагуулын өгөгдөл” гэж заасан боловч мэдээллийн эх сурвалжийн эрх зүйн хүчин чадал, мэдээлэл хоорондоо зөрсөн тохиолдолд баримтлах дараалал, мэдээллийг баталгаажуулах үндсэн зарчим тодорхой бус тул индексийн мэдээлэл, баталгаажуулалт, маргаан шийдвэрлэлттэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг хуулийн төсөлд тодорхой тусгах шаардлагатай;

7.Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт “Даатгуулах нэгжийн бүртгэл, кодчилол, баталгаажуулалтын журам”, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт “Индексийн мэдээллийг нийтэд мэдээлэх журам”, 8.5 дахь хэсэгт “индекс тооцох аргачлал, мэдээллийг баталгаажуулах журам”, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт “... хараат бус эксперт, аудитын дүгнэлт гаргуулах журам”-ыг тус тус батлахаар заасан боловч тухайн журмыг батлах байгууллага, эрх хэмжээний хүрээ, зохицуулах харилцааны үндсэн агуулгыг тодорхойлоогүй байна.

Энэ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 27^1 дүгээр зүйлийн $27^1.1$ дэх хэсгийн “Хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт тусгахад дараах шаардлагыг хангасан байна: $27^1.1.4$.зорилго, зохицуулах харилцааны хүрээг тодорхой тусгасан байх;” гэсэн шаардлагад нийцэхгүй байх тул захиргааны хэм хэмжээний актын зорилго, зохицуулах харилцааны хүрээг тодорхой тусгах шаардлагатай;

8.Хуулийн төслийн 12 дугаар зүйлд даатгалын гэрээний нөхцөл, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг болон 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт даатгалын үнэлгээ, хураамжтай холбоотой зохицуулалтыг тусгасан нь Иргэний хууль болон Даатгалын тухай хуульд нэгэнт зохицуулагдсан нийтлэг харилцааг давтсан шинжтэй байна.

Иймд тариалангийн индексжүүлсэн даатгалын онцлогтой холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгаж, нийтлэг харилцааны давхардлыг арилгах нь зүйтэй байна;

9.Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт "Тухайн эрсдэлийн индексийн албан ёсны мэдээлэл нийтэд зарлагдсан өдрөөс хойш гэрээнд заасан хугацаанд нөхөн төлбөр олгоно" гэж заасан боловч нөхөн төлбөр олгох хугацааны дээд хязгаар, хугацаа хэтэрсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, маргаан үүссэн нөхцөлд мөрдөх журмыг тодорхой тусгаагүй байна. Индексжүүлсэн даатгалын үндсэн онцлог нь нөхөн төлбөрийг шуурхай, урьдчилан тодорхойлсон нөхцөлөөр олгоход оршдог тул нөхөн төлбөр олгох хугацаа, холбогдох журам, хариуцлагын зохицуулалтыг тодорхой тусгах шаардлагатай.

Түүнчлэн төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт Санхүүгийн зохицуулах хороо, Засаг дарга, давхар даатгалын компанийн удирдлага хяналт хэрэгжүүлэх байгууллагуудын чиг үүрэг, эрх хэмжээний зааг, хяналтын хамрах хүрээ тодорхойгүй байгааг анхаарах;

10.Хуулийн төслийн 13 дугаар зүйлд суурь зөрүү болон даатгагчийн мэдээлэх үүрэгтэй холбоотой зохицуулалтыг тусгахдаа даатгагчийн мэдээлэх, тайлбарлах үүргийг ерөнхий байдлаар томьёолсон байх бөгөөд мэдээллийн хамрах хүрээ, хэлбэр, хэрэгжүүлэх журам, үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхой тусгах шаардлагатай байна.

Мөн хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтад "сумын дундаж болон тариалангийн талбайн ургацын индекс"-д суурилсан даатгалын хэлбэрийг тусгасан нь тухайн даатгуулагчийн бодит хохирол болон индексийн үзүүлэлт хооронд суурь зөрүү үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй байгааг анхаарч, даатгалын нэгжийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид суурилан тогтоохоос гадна боломжтой тохиолдолд газар зүйн координат, талбайн бүртгэл, таримлын төрөл, хөрсний болон цаг уурын бүсчлэл зэрэг үзүүлэлттэй уялдуулан тогтоох зарчмыг судлан тусгах;

11.Хуулийн төслийг хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой уялдуулах, нэр томьёо болон хэл зүй, найруулга, томьёоллыг нэг мөр болгох, төрийн санхүүгийн үүрэг болон эрсдэлийн сангийн зохицуулалтыг тодорхой болгох, индексийн мэдээлэл, баталгаажуулалт, хяналт, маргаан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой суурь зохицуулалтыг боловсронгуй болгож, холбогдох төрийн болон мэргэжлийн байгууллага, даатгалын болон давхар даатгалын байгууллага, тариаланчдын төлөөллийг оролцуулсан өргөн хүрээний хэлэлцүүлгийн үндсэн дээр дахин боловсруулах шаардлагатай.

Түүнчлэн Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 128-д Тариалангийн даатгалын тухай хуулийн төслийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан

боловсруулахаар тусгасан бөгөөд тус яамнаас холбогдох судалгаа, тооцоонд үндэслэн хуулийн төслийг боловсруулж байгааг харгалзан үзэх нь зүйтэй байна." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН: С.ЭРДЭНЭБОЛД

2026.03.01

ТАРИАЛАНГИЙН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон шаардлага, практик хэрэгцээ

1.1. Хуулийн төсөл боловсруулах болсон шаардлага

Монгол Улсад даатгалын үйл ажиллагааны нийтлэг харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Статистикийн тухай хууль, Тариалангийн тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоор зохицуулж ирсэн. Харин уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд тариалангийн салбарын байгаль, цаг уурын эрсдэлийн онцлогт нийцсэн индексэд суурилсан даатгалын харилцааг тусгайлан, иж бүрэн зохицуулсан бие даасан хууль өнөөдрийг хүртэл байхгүй байна.

Даатгалын тухай хуульд тариалангийн индексийн мэдээллийн эх сурвалж, босго үзүүлэлт, нөхөн төлбөрийн хүснэгт, суурь зөрүү, даатгуулагчийн мэдээллийн хамгаалалт, гэрээний онцлог нөхцөл зэрэг индексжүүлсэн даатгалын нарийвчилсан зохицуулалт тусгагдаагүй байна.

Үрийн тариалангийн даатгалын тухай хууль 1999 онд батлагдсан бөгөөд уг хууль нь зөвхөн үрийн тариаланг заавал даатгах болон зарим уламжлалт зохицуулалтыг агуулсан, бодит хохирол тогтоох зарчимд тулгуурласан байна. Тус хуулиар Монгол Улсад үрийн зориулалттай тариаланг тодорхой хувь, талбайн хэмжээнд албан журмаар даатгуулах харилцааны эрх зүйн үндсийг тогтоосон бөгөөд системийн шинжтэй их хэмжээний хохирол үүссэн тохиолдолд төрөөс нөхөн төлбөрийн зөрүүг хариуцах боломжийг хуульчилснаараа төрийн оролцоотой уламжлалт даатгалын загвартай бөгөөд үндсэндээ хэрэгжээгүй байна.

Газар тариалангийн үйлдвэрлэл нь хур тунадас, температур, хөрсний чийг, ган, хуурайшил, халууны давалгаа зэрэг уур амьсгалын хүчин зүйлээс ихээхэн хамааралтай, өндөр эрсдэлтэй салбар юм. Ийм эрсдэлийн үед бодит хохирлыг газар дээр нь тогтоож үнэлэх уламжлалт аргачлал нь цаг хугацаа, зардал их шаарддаг, маргаан дагуулдаг, ялангуяа жижиг, дунд хэмжээний тариалан эрхлэгчдэд хүртээмж багатай байдаг.

Индексжүүлсэн даатгал нь бодит хохирлыг газар дээр нь үнэлэхээс илүүтэйгээр тухайн даатгалын нэгжид тооцогдох индексийн үзүүлэлт урьдчилан тогтоосон босгыг хангасан эсэхэд үндэслэн нөхөн төлбөр олгодог онцлогтой. Иймд индексийн төрөл, мэдээллийн эх сурвалж, тооцох аргачлал, босго үзүүлэлт, нөхөн төлбөрийн шаталсан болон хэсэгчлэн олгох загвар, суурь зөрүү, хэмжилт–

тайлагнал–баталгаажуулалтын тогтолцоо, эрсдэлийн олон давхар хуваарилалт, давхар даатгал, даатгуулагчийн эрхийн хамгаалалтыг бие даасан хуулиар нарийвчлан тогтоох шаардлага үүссэн.

1.2. Практик хэрэгцээ

Тариалангийн салбар нь Монгол Улсын хүнсний аюулгүй байдал, боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн нийлүүлэлт, хөдөө орон нутгийн орлого, ажлын байртай шууд холбоотой стратегийн ач холбогдолтой салбар мөн. Гэвч уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын хэлбэлзэл нэмэгдэж, ган, хуурайшил, хэт халалт, хөрсний чийгийн дутагдал зэрэг эрсдэл нэмэгдэхийн хэрээр ургацын хэлбэлзэл өсч, тариаланчдын орлого тогтворгүй болох, санхүүгийн дарамт нэмэгдэх, зээл, хөрөнгө оруулалт татах чадвар сулрах сөрөг үр дагавар бий болж байна.

Индексжүүлсэн даатгал нь практикт дараах хэрэгцээг хангах боломжтой. Нэгдүгээрт, нөхөн төлбөрийг бодит хохирлын үнэлгээнд бус индексийн албан ёсны мэдээлэлд үндэслэн олгох тул шийдвэр гаргалт хурдан, зардал багатай, илүү ил тод байна. Хоёрдугаарт, индексийн мэдээллийг албан ёсны, тогтмол, шалгагдахуйц эх сурвалжаар тооцож нийтэд мэдээлэх боломжтой тул итгэлцэл нэмэгдэнэ. Гуравдугаарт, эрсдэлийг даатгуулагч, даатгагч, хамтын эрсдэлийн сан, давхар даатгал, шаардлагатай тохиолдолд төрийн дэмжлэгээр олон давхар хамгаалалтын хэлбэрээр хуваарилах нөхцөл бүрдэнэ. Дөрөвдүгээрт, суурь зөрүүний эрсдэл, нөхөн төлбөр олгогдох болон олгогдохгүй нөхцөл, даатгалын бүтээгдэхүүний үндсэн мэдээллийг даатгуулагчид урьдчилан ойлгомжтой хүргэх боломж бүрдэнэ.

Хуулийн төсөлд практик хэрэгцээг харгалзан индексийн мэдээллийн эх үүсвэрийг өргөжүүлж, цаг уурын албан ёсны мэдээлэл, даатгуулагчийн талбайд байршуулсан мэдрэгч төхөөрөмжийн мэдээлэл, ургацын статистик, зайнаас тандан судлал, хиймэл дагуулын өгөгдөл, баталгаажсан агро-мэдээллийн системийг ашиглах боломжийг тусгасан. Мөн даатгалын хамрах нэгжийг таримлын төрөл, газарзүйн байршил, даатгалын хугацаатай уялдуулан тогтоох, даатгуулах талбайг газар зүйн мэдээллийн системд бүртгэх, нэгжийн ангилал, индексийн тохирлыг тогтмол шинэчлэх, индексийн мэдээллийг хэмжилт–тайлагнал–баталгаажуулалтын тогтолцоонд тулгуурлан зохион байгуулах, богино хугацаанд бага талбайд нөлөөлөх зарим эрсдэлийг Даатгалын тухай хуулиар зохицуулах зэрэг нарийвчилсан зохицуулалтыг тусгасан нь хуулийн практик ач холбогдлыг нэмэгдүүлж байна.

1.3. Хууль зүйн үндэслэл

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хавсралтаар баталсан төлөвлөгөөний 1.1.6-д “Тариалангийн даатгалын тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3.1-д “Санхүү, даатгал, хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилнэ”, 3.3.4.9-д “Байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог сайжруулна” гэж, мөн Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль

тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл"-ийн 128-д "Тариалангийн даатгалын тухай" хууль батлахаар тус тус заасан байна.

Иймд тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бие даасан хуулиар тогтоох, даатгалын эрсдэлийг хуваарилах, нөхөн төлбөр төлөх, даатгуулагч, даатгагч болон давхар даатгалын компанийн эрх, үүрэг, төрийн оролцоо, хяналт, хэрэглэгчийн эрхийн хамгаалалтыг тодорхойлох хууль зүйн үндэслэл бүрдсэн байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго

Хуулийн төслийн зорилго нь тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, даатгалын эрсдэлийг хуваарилах, нөхөн төлбөр төлөх, даатгуулагч болон даатгагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Энэ зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Тариалангийн индексжүүлсэн даатгалын нэр томьёо, зарчим, хамрах хүрээ, бүтээгдэхүүний хэлбэр, даатгалын нэгжийг хууль зүйн хувьд нэг мөр тодорхойлох;
2. Индексийн мэдээллийн эх үүсвэр, техникийн шаардлага, өгөгдлийн стандарт, тооцооллын аргачлал, босго үзүүлэлт, мэдээллийг хэмжих, цуглуулах, боловсруулах, тайлагнах, баталгаажуулах тогтолцоог хуульчлах;
3. Нөхөн төлбөрийг индексийн үзүүлэлтийн өөрчлөлттэй уялдуулан шаталсан болон хэсэгчлэн олгох, нөхөн төлбөрийн дээд хязгаарыг тогтоох эрх зүйн механизмыг бүрдүүлэх;
4. Даатгалын гэрээний онцлог нөхцөл, суурь зөрүүний талаарх мэдээллийн үүрэг, даатгалын бүтээгдэхүүний товч танилцуулга, гомдол, маргаан шийдвэрлэх зохицуулалтаар даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах;
5. Даатгалын эрсдэлийг доод, дунд, дээд түвшинд хуваарилж, хамтын эрсдэлийн сан, давхар даатгалын компани, түүний сан болон олон улсын давхар даатгалын механизмыг ашиглан эрсдэлийн олон шатлалт хамгаалалтыг бүрдүүлэх;
6. Тариалангийн индексжүүлсэн даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсөв, төсвийн боломжид нийцүүлэн даатгалын хураамжийн тодорхой хэсэгт төрөөс дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлэх, индекс тооцоход шаардлагатай өгөгдөл, мэдээллийн дэд бүтцийг сайжруулах;
7. Хуулийн хэрэгжилтийг туршилтын аймаг, сум, өгөгдлийн бэлэн байдал хангагдсан таримал, индексийн төрлөөс эхлэн үе шаттай хэрэгжүүлж, үр дүнг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр үнэлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх.

Гурав. Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэхүү хуулиар тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаатай холбогдон үүсэх тусгай харилцааг зохицуулна. Даатгалтай холбоотой нийтлэг харилцааг Иргэний хууль, Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль

тогтоомжоор зохицуулах бөгөөд тариалангийн индексжүүлсэн даатгалын онцлог харилцааг энэ хуулиар тусгайлан зохицуулна.

Хуулийн төслийн хамрах хүрээнд тариаланч иргэн, хуулийн этгээд сайн дурын үндсэн дээр даатгуулж болохоор тусгасан. Мөн даатгагч, давхар даатгалын компани, хамтын эрсдэлийн сан, статистик, цаг уур, газар тариалангийн мэдээлэл хариуцсан байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

Хуулийн төсөлд зохицуулалтын дараах үндсэн агуулгыг хамруулна. Үүнд:

- индексжүүлсэн даатгалд хур тунадас, ган, температур, халуун, хөрсний чийг, таримал ургамлын өсөлт, зайнаас тандан судлал, сумын дундаж болон тариалангийн талбайн ургацын индекс, түүнчлэн хоёр ба түүнээс дээш индексийн үзүүлэлтэд суурилсан бүтээгдэхүүнийг ашиглах;
- даатгалын нэгжийг таримлын төрөл, талбайн хэмжээ, байршил, тариалангийн бүс дэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, талбар болон даатгалын хугацаатай уялдуулан тодорхойлох;
- даатгалд хамрагдах талбайг газар зүйн мэдээллийн нэгдсэн системд бүртгэх, давхардалгүй код олгох, бүртгэлийн мэдээллийг шалгах, баталгаажуулах;
- индексийн мэдээллийн албан ёсны, тогтмол, шалгагдахуйц эх үүсвэр, өгөгдлийн чанар, хүртээмж, баталгаажуулалт, мэдээллийг нийтэд мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх;
- индексийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, тооцох, чанарыг шалгах, хөндлөнгийн баталгаажуулалт хийх, хадгалах, нийтэд мэдээлэх болон мэдээллийн зөрүүг шийдвэрлэх;
- даатгалын гэрээнд ашиглах индекс, мэдээллийн эх үүсвэр, индекс тооцох аргачлал, босго үзүүлэлт, нөхөн төлбөрийн хүснэгт, даатгалын үнэлгээ, суурь зөрүүний эрсдэл, мэдээлэл нийтлэх болон нөхөн төлбөр олгох хугацаа, гомдол, маргаан шийдвэрлэх нөхцөлийг тусгах;
- даатгалын бүтээгдэхүүний үндсэн нөхцөл, эрсдэл, нөхөн төлбөрийн зарчмыг нэгтгэсэн товч танилцуулгыг даатгуулагчид заавал хүргүүлэх;
- эрсдэлийг доод, дунд, дээд түвшинд хуваарилж, хамтын эрсдэлийн сан, давхар даатгалын компани, түүний сан болон олон улсын давхар даатгалын механизмаар санхүүгийн хамгаалалт бүрдүүлэх;
- төрөөс тухайн жилийн батлагдсан улсын төсөв, төсвийн боломжид багтаан даатгалын хураамжийн тодорхой хэсэгт дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлэх;
- индекс тооцоход шаардлагатай цаг уурын ажиглалт, ургацын статистик, зайнаас тандан судлал, газарзүйн мэдээлэл болон бусад мэдээллийн дэд бүтцийн чанар, хүртээмж, харилцан ажиллагааг сайжруулах;

- мөндөр, хяруу, үер, цасан болон шороон шуурга, өвчин, хортон шавж, мэрэгчийн нөлөө зэрэг индексэд хамааруулах боломжгүй, богино хугацаанд бага талбайг хамарсан эрсдэлийг Даатгалын тухай хуулиар зохицуулах;
- хуулийн хэрэгжилтийг туршилтын аймаг, сум, өгөгдлийн бэлэн байдал хангагдсан таримал, индексийн төрлөөс эхлэн үе шаттай хэрэгжүүлэх.

Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа зарим хуулийн зохицуулалтыг шинэ хуулийн зохицуулалттай нийцүүлэх, хууль хоорондын давхардал, зөрчлийг арилгах, тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааны эрх зүйн уялдааг хангах зорилгоор дараах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.

Даатгалын тухай хуульд малын болон тариалангийн индексжүүлсэн даатгалын харилцааг тус тусын хуулиар зохицуулахаар зааж, тариалангийн индексжүүлсэн даатгалын эрх зүйн зохицуулалтыг уг хуулиас тусгайлан зааглах агуулгаар нэмэлт, өөрчлөлт оруулахаар боловсруулав.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалт, хяналтын чиг үүрэгт хамруулах агуулгаар нэмэлт, өөрчлөлт оруулахаар боловсруулав.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд давхар даатгалын компани, хамтын эрсдэлийн сан болон давхар даатгалын компанийн сангийн зохицуулалтыг тариалангийн индексжүүлсэн даатгалд хэрэглэх, дунд болон дээд түвшний эрсдэлийг санхүүжүүлэх, холбогдох хөрөнгө, орлого, зарлага, өр төлбөрийг тусад нь бүртгэж тайлагнах агуулгаар нэмэлт оруулахаар боловсруулав.

Тариалангийн тухай хуульд тариалангийн индексжүүлсэн даатгалтай холбогдсон харилцааг Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулахаар өөрчлөлт оруулахаар боловсруулав.

Дөрөв. Хуулийн төслийн ерөнхий бүтэц

Хуулийн төсөл нь найман бүлэгтэй байна.

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, хууль тогтоомжийн бүрэлдэхүүн, үйлчлэх хүрээ, үндсэн нэр томьёог тодорхойлно. Энэ бүлэгт “алдагдлаас хамгаалах сан”, “босго үзүүлэлт”, “давхар даатгалын компани”, “даатгалын нэгж”, “даатгалын нөхөн төлбөр”, “даатгалын тохиолдол”, “даатгалын үнэлгээ”, “даатгалын хамрах хугацаа”, “индекс”, “нөхөн төлбөрийн хүснэгт”, “суурь зөрүү”, “тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа”, “хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт”, “хамтын эрсдэлийн сан”, “эрсдэлийн дунд түвшин”, “эрсдэлийн дээд түвшин” зэрэг үндсэн ойлголтыг тодорхойлно.

Хоёрдугаар бүлэгт даатгалын үйл ажиллагаанд баримтлах зарчим, индексэд суурилсан даатгалын хэлбэр, даатгалын нэгж, индексийг сонгох шалгуур, даатгалд хамруулах таримал, талбайн байршил, хугацаа, газар зүйн мэдээллийн систем дэх бүртгэл, кодчилол, баталгаажуулалт, даатгалын үнэлгээтэй холбоотой харилцааг зохицуулна.

Гуравдугаар бүлэгт индексийн мэдээллийн эх үүсвэр, түүнд тавих шаардлага, мэдээллийг нийтэд мэдээлэх, индексийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, чанарыг шалгах, хөндлөнгийн баталгаажуулалт хийх, хадгалах, мэдээллийн зөрүүг шийдвэрлэх, босго үзүүлэлтийг тогтоох, эрсдэлийн түвшин болон нөхөн төлбөрийн шаталсан, хэсэгчлэн олгох механизмыг тодорхойлно.

Дөрөвдүгээр бүлэгт даатгалын хураамжийн актуар үндэслэл, даатгалын гэрээний онцлог нөхцөл, суурь зөрүүний талаарх мэдээллийн үүрэг, нөхөн төлбөр олгох журам, даатгуулагчийн эрхийг хамгаалах, даатгалын бүтээгдэхүүний товч танилцуулга, санхүүгийн боловсрол олгохтой холбоотой зохицуулалтыг тусгана.

Тавдугаар бүлэгт эрсдэлийг доод, дунд, дээд түвшинд хуваарилах, хамтын эрсдэлийн сан, давхар даатгалын компани, олон улсын давхар даатгал, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасан сангийн тогтолцоог тариалангийн индексжүүлсэн даатгалд ашиглах, сангийн хөрөнгө, орлого, зарлага, өр төлбөрийг тусад нь бүртгэж тайлагнах, төлөөлөн удирдах зөвлөл, нууцлал, тайлан, аудит, нийтэд мэдээлэх асуудлыг зохицуулна.

Зургаадугаар бүлэгт тариалангийн индексжүүлсэн даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсөв, төсвийн боломжид багтаан даатгалын хураамжийн тодорхой хэсэгт дэмжлэг үзүүлэх, дэмжлэгийн зорилтот бүлэг, шалгуур, хувь хэмжээ, дээд хязгаар, олгох нөхцөлийг тогтоох, мөн индекс тооцоход шаардлагатай өгөгдөл, мэдээллийн дэд бүтцийн чанар, хүртээмж, харилцан ажиллагааг сайжруулахтай холбоотой зохицуулалтыг тусгана.

Долоодугаар бүлэгт хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, гомдол, маргаан шийдвэрлэх, индексийн мэдээлэл, тооцоололтой холбоотой маргаанд хараат бус шинжээч ашиглах болон хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын асуудлыг зохицуулна.

Наймдугаар бүлэгт хуулийн хэрэгжилтийг туршилтын аймаг, суманд эхлүүлэх, эрсдэлийн үнэлгээ, өгөгдлийн бэлэн байдал хангагдсан таримал, индексийн төрлөөр эхний ээлжид хэрэгжүүлэх, цаашид таримлын нэр төрөл болон индексийн төрлийг үе шаттай өргөжүүлэх, туршилтын хэрэгжилтийн үр дүнг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр үнэлэх, үнэлгээний дүнд үндэслэн хуульд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчин төгөлдөр болох хугацааг зохицуулна.

Тав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

5.1. Нийгэм, эдийн засгийн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар тариаланчдын байгаль, цаг уурын эрсдэлийг даван туулах санхүүгийн чадавх сайжрах, ургацын хэлбэлзлээс шалтгаалах орлогын савлагааг бууруулах, үйлдвэрлэлийн тасралтыг багасгах, хөрөнгө оруулалт болон санхүүжилт татах нөхцөлийг сайжруулах боломж бүрдэнэ.

Нөхөн төлбөрийг бодит хохирлыг нэг бүрчлэн газар дээр нь тогтоохоос илүүтэйгээр албан ёсны индексийн мэдээлэл болон гэрээнд урьдчилан тохирсон нөхөн төлбөрийн хүснэгтэд үндэслэн олгох нь нөхөн төлбөрийн ажиллагааг шуурхай, ил тод, зардал багатай хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Эрсдэлийг даатгуулагч, даатгагч, хамтын эрсдэлийн сан, давхар даатгалын компани болон олон улсын давхар даатгалын механизмаар шатлан хуваарилснаар их хэмжээний системийн эрсдэлийг санхүүгийн хувьд тогтвортой удирдах боломж нэмэгдэнэ.

Төрөөс тариалангийн индексжүүлсэн даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тухайн жилийн батлагдсан улсын төсөв, төсвийн боломжид багтаан даатгалын хураамжийн тодорхой хэсэгт дэмжлэг үзүүлэх боломж бүрдэх бөгөөд уг дэмжлэгийг зорилтот бүлэг, шалгуур, хувь хэмжээ, дээд хязгаар, олгох нөхцөлтэй уялдуулан хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бий болно.

5.2. Хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар тариалангийн индексжүүлсэн даатгалын нэр томьёо, бүтээгдэхүүн, даатгалын нэгж, индексийн мэдээллийн эх үүсвэр, босго үзүүлэлт, нөхөн төлбөрийн хүснэгт, гэрээний онцлог нөхцөл, мэдээллийн үүрэг, эрсдэлийн хуваарилалт, давхар даатгал, төрийн дэмжлэг, хяналт, гомдол, маргаан шийдвэрлэхтэй холбоотой харилцааны эрх зүйн зохицуулалт тодорхой болно.

Даатгагч нь суурь зөрүүний утга, үүсэх шалтгаан, болзошгүй үр дагавар болон бодит хохирол учирсан боловч нөхөн төлбөр олгогдохгүй байж болох нөхцөлийг даатгуулагчид гэрээ байгуулахаас өмнө ойлгомжтой тайлбарлах үүрэгтэй болсноор мэдээллийн тэгш бус байдлыг бууруулж, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах нөхцөл сайжирна.

Индексийн мэдээллийн эх үүсвэр, тооцооллын аргачлал, мэдээллийн чанар, баталгаажуулалт, мэдээллийг нийтэд мэдээлэх болон маргаан шийдвэрлэх механизмыг тодорхой болгосноор хуулийн хэрэгжилтийн ил тод байдал, даатгалын тогтолцоонд оролцогчдын итгэлцлийг нэмэгдүүлэх эрх зүйн нөхцөл бүрдэнэ.

Зургаа. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээтэй уялдах байдал

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчимтай нийцнэ. Тухайлбал, иргэн, хуулийн этгээдийн өмчлөх эрх, эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх эрх, гэрээний эрх чөлөөг хүндэтгэхийн зэрэгцээ хүнсний аюулгүй байдал, тогтвортой хөгжил, эрсдэлийн удирдлагыг дэмжих төрийн бодлоготой уялдана.

Хуулийн төсөл нь Иргэний хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Статистикийн тухай хууль, Тариалангийн тухай хуультай харилцан уялдаатай хэрэгжинэ. Даатгалтай холбоотой нийтлэг харилцааг эдгээр хууль тогтоомжоор зохицуулах бөгөөд тариалангийн индексжүүлсэн даатгалын онцлог харилцааг энэ хуулиар тусгайлан зохицуулна.

Түүнчлэн тариалангийн индексжүүлсэн даатгалын дээд түвшний эрсдэлийн давхар даатгал, олон улсын давхар даатгалтай холбоотой үйл ажиллагааг Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 18.1-д заасан давхар даатгалын компани хэрэгжүүлэх бөгөөд дунд болон дээд түвшний эрсдэлийг санхүүжүүлэхэд тус хуулийн 25–27 дугаар зүйлд заасан сангийн тогтолцоог ашиглахаар тусгасан.

Тариалангийн индексжүүлсэн даатгалд хамаарах хөрөнгө, орлого, зарлага, өр төлбөрийг тусад нь бүртгэж, тайлагнах замаар хоёр төрлийн индексжүүлсэн даатгалын санхүүгийн бүртгэл, хариуцлагыг зааглана.

Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөхөөр тусгасан тул Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгтэй нийцнэ.

Долоо. Хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоомжийн бусад зохицуулалт

Хуулийг хэрэгжүүлэхэд дараах журам, аргачлал болон зохицуулалтыг боловсруулж, батлах шаардлагатай. Үүнд:

1. Даатгалын нэгжийг бүртгэх, давхардалгүй код олгох, газарзүйн мэдээллийн системтэй холбох, бүртгэлийн мэдээллийг шалгах, баталгаажуулах журам;
2. Индексийн төрөл, техникийн шаардлага, өгөгдлийн стандарт, актуар болон тооцооллын аргачлал;
3. Индексийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, индекс тооцох, мэдээллийн чанарыг шалгах, хөндлөнгийн баталгаажуулалт хийх, хадгалах, нийтэд мэдээлэх давтамж, хэлбэр болон мэдээллийн зөрүүг шийдвэрлэх журам;
4. Даатгалын хураамж тогтоох, хэлэлцэх, баталгаажуулахтай холбоотой зохицуулалт;
5. Хамтын эрсдэлийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, санхүүжүүлэх, зарцуулах журам;
6. Давхар даатгалын компанийн санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах журам;
7. Төрөөс даатгалын хураамжид үзүүлэх дэмжлэгийн зорилтот бүлэг, шалгуур, хувь хэмжээ, дээд хязгаар болон олгох нөхцөл;
8. Индексийн мэдээлэл, тооцоололтой холбоотой маргааныг шийдвэрлэхэд ашиглах хараат бус шинжээчийг сонгох, түүнд тавих шаардлага, дүгнэлт гаргах хугацаа, талуудын оролцоо болон зардлыг хариуцах журам.

Эдгээр журам, аргачлал, зохицуулалтыг Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороо, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох төрийн байгууллага хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд батална.

Найм. Хуулийн төслийн хэрэгжилтийн үе шат, онцлог

Хуулийн хэрэгжилтийг шууд бүх нутаг дэвсгэрт нэгэн зэрэг нэвтрүүлэх бус, эхний ээлжид туршилтын аймаг, суманд хэрэгжүүлнэ. Туршилтын шатанд эрсдэлийн үнэлгээ, өгөгдлийн бэлэн байдал хангагдсан таримал, индексийн төрлийг сонгон хэрэгжүүлж, үр дүнд үндэслэн таримлын нэр төрөл болон индексийн төрлийг үе шаттай өргөжүүлнэ.

Туршилтын хэрэгжилтийн үр дүнг урьдчилан тогтоосон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр үнэлнэ. Туршилтын хугацааны хэрэгжилт, үр нөлөөний үнэлгээний дүнд үндэслэн шаардлагатай тохиолдолд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.

Ийнхүү үе шаттай хэрэгжүүлэх нь индексийн мэдээллийн чанар, даатгалын бүтээгдэхүүний бодит үр нөлөө, даатгуулагчийн ойлголт, эрсдэлийн хуваарилалт болон санхүүгийн тогтвортой байдлыг практик хэрэгжилтэд үндэслэн үнэлж, тогтолцоог боловсронгуй болгох боломж бүрдүүлнэ.

"Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай" хуулийн төсөл нь тариалангийн салбарын байгаль, цаг уурын эрсдэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй, ил тод, зах зээлийн болон даатгалын механизмд тулгуурлан удирдах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилготой анхдагч хуулийн төсөл юм.

Хуулийн төсөлд индексийн төрөл, даатгалын нэгж, мэдээллийн эх үүсвэр, босго үзүүлэлт, нөхөн төлбөрийн хүснэгт, даатгалын гэрээний онцлог нөхцөл, суурь зөрүүний эрсдэл, даатгуулагчийн эрхийн хамгаалалт, эрсдэлийн шаталсан хуваарилалт, хамтын эрсдэлийн сан, давхар даатгалын компани болон түүний сангийн тогтолцоо, төрийн дэмжлэг, мэдээллийн дэд бүтэц, хяналт, маргаан шийдвэрлэлт, туршилтын үе шаттай хэрэгжилтийн зохицуулалтыг тусгасан.

Иймд энэхүү үзэл баримтлал нь хуулийн төслийн зорилго, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, бүтэц, хэрэгжилтийн үр дагавар, бусад хууль тогтоомжтой уялдах байдал болон хэрэгжилтийн үе шатыг хуулийн төслийн шинэчилсэн агуулгатай нийцүүлэн тодорхойлсон суурь баримт бичиг болно.

Ес.Хуулийн төслийг батлахтай холбогдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон бусад хуульд нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан тус тус боловсруулна.

---oOo---

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАРИАЛАНГИЙН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, даатгалын эрсдэлийг хуваарилах, нөхөн төлбөр төлөх, даатгуулагч болон даатгагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хууль тогтоомж

2.1.Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Статистикийн тухай хууль, Тариалангийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Даатгалтай холбоотой нийтлэг харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

3.2.Тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаатай холбогдсон энэ хуулийн 3.1-д зааснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.3.Тариалангийн индексжүүлсэн даатгалд тариаланч иргэн, хуулийн этгээд даатгуулж болно.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёо

4.1.Энэ хуульд хэрэглэсэн нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“алдагдлаас хамгаалах сан” гэж тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаанаас үүсч болзошгүй санхүүгийн алдагдлыг шингээх, даатгагчийн төлбөрийн чадвар болон даатгалын тогтолцооны санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор бүрдүүлсэн нөөц санг;

4.1.2.“босго үзүүлэлт” гэж даатгалын тохиолдлыг тодорхойлох, эрсдэлийг хуваарилах зорилгоор тогтоосон, индексийн утгын өөрчлөлтөөс хамааран нөхөн төлбөрийг хувь тэнцүүлсэн эсхүл шаталсан байдлаар олгох түвшнийг;

4.1.3.“давхар даатгалын компани” гэж Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 18.1-д заасан давхар даатгалын компанийг;

4.1.4.“даатгалын нэгж” гэж даатгагч, даатгуулагч нар харилцан тохирч гэрээнд заасан индексжүүлсэн даатгалд хамруулах таримлын төрөл, талбайн хэмжээ, байршил, тариалангийн бүс дэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, талбар, даатгалын хугацаагаар тодорхойлогдох, даатгалын үнэлгээ тогтоох суурь нэгжийг;

4.1.5.“даатгалын нөхөн төлбөр” гэж даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид гэрээний дагуу олгох мөнгөн төлбөрийг;

4.1.6.“даатгалын тохиолдол” гэж тариалангийн индексийн үзүүлэлт нь энэ хууль болон даатгалын гэрээнд заасан босго нөхцөлийг хангасан байдлыг;

4.1.7.“даатгалын үнэлгээ” гэж даатгуулагчийн сонгосон даатгалын нэгжид ногдох бөгөөд даатгалын тохиолдол үүссэн үед нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлох суурь үзүүлэлт болох мөнгөн дүнг;

4.1.8.“даатгалын хамрах хугацаа” гэж даатгалд хамрагдах тухайн төрлийн таримлын тариалалтаас ургац хураалт хүртэлх хугацаа болон Засгийн газраас тогтоосон бусад хугацааг;

4.1.9.“индекс” гэж хур тунадас, температур, хөрсний чийг, гангийн индекс, тариалангийн бүс дэх ургацын сумын дундаж индекс зэрэг тариалангийн эрсдэлийг төлөөлөх статистик үзүүлэлтийг;

4.1.10.“нөхөн төлбөрийн хүснэгт” гэж индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөрийг тооцох зорилгоор индексийн босго, өөрчлөлтийн түвшин бүрд харгалзах нөхөн төлбөрийн хувь, хэмжээ, дээд хязгаар, шаталсан болон хэсэгчлэн олгох нөхцөлийг урьдчилан тогтоосон хүснэгтэн илэрхийллийг;

4.1.11.“суурь зөрүү” гэж индексийн үзүүлэлт болон даатгуулагчид бодитоор учирсан хохирол хооронд бүрэн нийцэл үүсэхгүй байх эрсдэлийг;

4.1.12. “тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа” гэж даатгуулагчид учирсан бодит хохирлоор бус, даатгалын хамрах хугацаанд тухайн нэгжид тооцогдох индексийн үзүүлэлт босго хэмжээнээс давсан тохиолдолд нөхөн төлбөр олгох даатгалын үйл ажиллагааг;

4.1.13.“хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт” гэж индексийн мэдээлэл, холбогдох өгөгдлийг цуглуулах, хэмжих, түүнд үндэслэн тооцоолол хийж тайлагнах, итгэмжлэгдсэн хараат бус хянан баталгаажуулагчийн дүгнэлтийг гаргуулсны үндсэн дээр даатгуулагч болон олон нийтэд мэдээлэх үйл ажиллагааны цогцыг;

4.1.14.“хамтын эрсдэлийн сан” гэж Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 4.1.13, 26 дугаар зүйлд заасан санг;

4.1.15.“эрсдэлийн дунд түвшин” гэж энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан хоёрдугаар босго хүртэлх, даатгагч хамтын эрсдэлийн сангаар хариуцах эрсдэлийн түвшнийг;

4.1.16. “эрсдэлийн дээд түвшин” гэж хоёрдугаар босгоос давсан, давхар даатгалын компани болон түүний сан, давхар даатгалаар хариуцах эрсдэлийн түвшнийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
ДААТГАЛЫН ЗАРЧИМ, БҮТЭЭГДЭХҮҮН, НЭГЖ

5 дугаар зүйл.Үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1.Тариалангийн индексжүүлсэн даатгал дараах зарчимд тулгуурлана:

5.1.1.сайн дурын, тэгш хүртээмжтэй байх;

5.1.2.индекс тооцох, нөхөн төлбөр олгох аргачлал нь шинжлэх ухааны үндэслэлтэй, ил тод байх;

5.1.3.эрсдэлийг хуваарилах давхар хамгаалалттай байх;

5.1.4.суурь зөрүүний талаар даатгуулагчид урьдчилан мэдээлэх;

5.1.5. өгөгдлийн чанар, баталгаажуулалт, хараат бус хяналтыг хангах;

5.1.6. даатгуулагч, даатгагчийн эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангах, маргаан шийдвэрлэх тодорхой журамтай байх.

6 дугаар зүйл.Даатгалын хэлбэр, нэгж

6.1.Тариалангийн индексжүүлсэн даатгалд цаг уур, хөрс, ургамлын өсөлтийн төлөв байдал, ургац болон тариалангийн эрсдэлийг бодитой төлөөлөх дор дурдсан нэг буюу хэд хэдэн индексийг ашиглаж болно.

6.1.1.хур тунадас/гангийн индексэд суурилсан;

6.1.2.температур/халууны индексэд суурилсан;

6.1.3.хөрсний чийг, таримал ургамлын өсөлт, саатлыг зайнаас тандах индексэд суурилсан;

6.1.4.сумын дундаж болон тариалангийн талбайн ургацын индексэд суурилсан;

6.1.5.хоёр ба түүнээс дээш индексийн үзүүлэлтэд суурилсан даатгалын бүтээгдэхүүн.

6.2.Энэ хуулийн 6.1-д заасан индексийг сонгохдоо тухайн таримал, газар зүйн бүс, даатгалын нэгжийн эрсдэлийг төлөөлөх чадвар, өгөгдлийн хүртээмж, чанар, болон статистик хамаарлыг харгалзана.

6.3.Индексийн төрөл, техникийн шаардлага, өгөгдлийн стандарт, актуар болон тооцооллын аргачлалыг газар тариалан, цаг уур, статистикийн асуудал эрхэлсэн байгууллагын саналыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хороо батална.

6.4.Даатгалын хамрах нэгжийг дараах байдлаар тогтооно:

6.4.1.таримлын төрөл: даатгалын гэрээнд заасан таримлын төрөл;

6.4.2.талбайн байршил: газарзүйн мэдээллийн системд суурилан тариалангийн талбайн торон нэгж, эсхүл засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж;

6.4.3.даатгалын хугацаа: даатгалын гэрээнд заасан тариалалтаас хураалт хүртэлх хугацаа.

6.5.Даатгуулагч нь даатгалд хамруулах талбайн эзэмших, ашиглах эрхийн баримт бичиг, эсхүл хууль ёсны ашиглалтын нотолгоог бүрдүүлнэ.

6.6.Даатгалд хамрагдах талбайг газар зүйн мэдээллийн нэгдсэн системд бүртгэж, индексийн тооцоонд ашиглана.

6.7.Даатгалын нэгжийг бүртгэх, давхардалгүй код олгох, газарзүйн мэдээллийн системтэй холбох, бүртгэлийн мэдээллийг шалгах, баталгаажуулах журмыг Засгийн газар батална.

6.8.Даатгалын нэгжийн ангилал, индексийн тохирлыг гурван жил тутам шинэчлэн тогтооно.

6.9.Энэ хуулийн 6.1-д заасан индексэд хамаарах боломжгүй мөндөр, хяруу, үер, цасан болон шороон шуурга, өвчин, хортон шавж, мэрэгчийн нөлөө зэрэг богино хугацаанд, бага талбайг хамарсан байгалийн гамшгийн эрсдэлийг Даатгалын тухай хуулиар зохицуулна.

7 дугаар зүйл.Даатгалд хамруулах таримал, үнэлгээ

7.1.Индексжүүлсэн даатгалд хамруулах таримлын нэр төрлийг даатгагч, даатгуулагч харилцан тохиролцож даатгалын гэрээнд тусгана.

7.2.Тариалангийн бүсийн хүрээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дагуу сум эсхүл талбайг бүсчилж, тухайн нэгжид тохирох индексийг таримлын нэр төрлөөр сонгон хэрэглэнэ.

7.3.Даатгалын үнэлгээг тухайн таримлын нэгж талбайд ногдох түүхэн дундаж ургац, даатгалын гэрээ байгуулах үеийн зах зээлийн дундаж үнэ болон даатгалын хамрах хувийг харгалзан тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
ИНДЕКСИЙН МЭДЭЭЛЭЛ, БОСГО ҮЗҮҮЛЭЛТ

8 дугаар зүйл.Индексийн мэдээллийн эх үүсвэр, нийтэд мэдээлэх

8.1.Индексийн тооцоонд ашиглах мэдээллийн эх үүсвэр нь дараах шаардлагыг хангана:

8.1.1.албан ёсны, тогтмол, шалгагдахуйц байх;
8.1.2.аргачлал нь нийтэд нээлттэй байх;
8.1.3.тухайн нэгжид төлөөлөхүйц нягтрал, чанартай байх.

8.2.Индексийн тооцоонд дараах эх үүсвэрийг ашиглана:

8.2.1.цаг уурын албан ёсны ажиглалтын мэдээлэл;
8.2.2.эрх бүхий байгууллагаас тогтоосон техникийн болон чанарын шаардлага хангасан, баталгаажуулах боломжтой автомат станц, мэдрэгч төхөөрөмжийн мэдээлэл;

8.2.3.Үндэсний статистикийн байгууллагын ургацын мэдээлэл;
8.2.4.эх сурвалж, боловсруулалтын аргачлал, нарийвчлал нь тодорхой, баталгаажуулах боломжтой зайнаас тандан судлал, хиймэл дагуулын өгөгдөл;

8.2.5. баталгаажсан бусад агро-мэдээллийн систем.

8.3.Индексийн албан ёсны мэдээллийг статистик, цаг уур, газар тариалангийн мэдээллийн нэгдсэн тогтолцоогоор дамжуулан нийтэд мэдээлнэ.

8.4.Индексийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, индекс тооцох, мэдээллийн чанарыг шалгах, хөндлөнгийн баталгаажуулалт хийх, мэдээллийг хадгалах, нийтэд мэдээлэх давтамж, хэлбэр болон мэдээллийн зөрүүг шийдвэрлэх журмыг Засгийн газар батална.

8.5.Индексийн тооцоонд ашиглах мэдээллийн эх үүсвэр, мэдээлэл ашиглах эрх, чанарын шаардлага, мэдээллийг тулган шалгах, баталгаажуулах, хадгалах болон мэдээллийн зөрүүг шийдвэрлэх нөхцөл, журмыг энэ хуулийн 8.4-т заасан журмаар зохицуулна.

9 дүгээр зүйл.Босго үзүүлэлтийг тогтоох

9.1.Даатгалын тохиолдлыг тодорхойлох, эрсдэлийг хуваарилах босго үзүүлэлтийг Засгийн газар тариалангийн бүс дэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, таримал ургамлын төрөл бүрээр дараах байдлаар тогтооно:

9.1.1.даатгуулагчийн өөрийн эрсдэл хүлээх нэгдүгээр босго;
9.1.2.даатгагч буюу хамтын сангийн эрсдэл хүлээх хоёрдугаар босго;
9.1.3.давхар даатгалын компани болон төрийн хамгаалалтын дээд түвшний босго.

9.2.Босго үзүүлэлтийг тогтоохдоо талбайн түүхэн өгөгдөл, уур амьсгалын эрсдэлийн зураглал, ургацын хэлбэлзэл, даатгалын хамрагдалт, хураамж/нөхөн төлбөрийн гүйцэтгэл зэргийг харгалзан үзнэ.

9.3.Босго үзүүлэлтийг жил тутам шинэчлэн тогтооно.

10 дугаар зүйл.Эрсдэлийн түвшин, нөхөн төлбөрийн шатлал

10.1.Босго үзүүлэлтийг үндэслэн эрсдэлийн түвшнийг бага, дунд, дээд гэж ангилна.

10.2.Нөхөн төлбөрийг индексийн үзүүлэлтийн өөрчлөлтөөс хамааран дараах зарчмаар тооцож олгоно:

10.2.1.индексийн үзүүлэлт даатгалын тохиолдол гэж тооцох босгыг хангаж, түүнээс давсан хэмжээнээс хамааран нөхөн төлбөрийн хэмжээ шаталсан байдлаар нэмэгдэх;

10.2.2.индексийн үзүүлэлт эрсдэлийн дунд түвшний босго хэмжээнд хүрсэн тохиолдолд нөхөн төлбөрийг хэсэгчлэн олгох;

10.2.3.индексийн үзүүлэлт эрсдэлийн дунд түвшний босго хэмжээнээс нэмэгдсэн тохиолдолд нөхөн төлбөрийг хэсэгчлэн болон шаталсан байдлаар олгох;

10.2.4.нөхөн төлбөрийн нийт хэмжээ тухайн даатгалын нэгжид тогтоосон даатгалын үнэлгээнээс хэтрэхгүй дээд хязгаартай байх.

10.3.Индексийн үзүүлэлтийн өөрчлөлтөөс үүдэн бодит хохиролтой бүрэн нийцэхгүй байх эрсдэлийг бууруулах зорилгоор нөхөн төлбөрийг индексийн өөрчлөлтийн түвшинтэй уялдуулан шаталсан загвараар тооцно.

10.4.Нөхөн төлбөрийн хүснэгт нь даатгалын гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд индексийн босго, өөрчлөлтийн түвшин бүрд харгалзах нөхөн төлбөрийн хувь, төлбөрийн дээд хязгаар болон хэсэгчлэн, шаталсан байдлаар олгох нөхцөлийг агуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ДААТГАЛЫН ХУРААМЖ, ГЭРЭЭ, ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛТ

11 дүгээр зүйл.Даатгалын хураамж

11.1.Даатгалын хураамж нь эрсдэлийн түвшин, индексийн хэлбэлзэл, нөхөн төлбөрийн бүтэц, даатгалын дүнтэй уялдсан актуар тооцоонд үндэслэнэ.

11.2.Хураамж тогтоох, хэлэлцэх, баталгаажуулах зохицуулалтыг Даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан холбогдох журмыг үндэслэн батална.

11.3.Даатгагчид бүтээгдэхүүний нөхцөл, хураамжийн гол үзүүлэлтийг нийтэд ил тод мэдээлнэ.

12 дугаар зүйл.Даатгалын гэрээ

12.1.Тариалангийн индексжүүлсэн даатгалын гэрээнд Иргэний хууль, Даатгалын тухай хуульд заасан нөхцөлөөс гадна дараах онцлог нөхцөлийг тусгана:

12.1.1.даатгуулах таримлын төрөл, даатгалын нэгж, талбайн байршил, хамрах хугацаа;

12.1.2.ашиглах индекс, мэдээллийн эх үүсвэр болон индекс тооцох аргачлал;

12.1.3.босго үзүүлэлт, нөхөн төлбөрийн хувь, дээд хязгаарыг тусгасан нөхөн төлбөрийн хүснэгт;

12.1.4.даатгалын үнэлгээ болон даатгуулагчийн өөрийн хариуцах эрсдэлийн хэмжээ;

12.1.5.суурь зөрүүний эрсдэл, түүний болзошгүй үр дагавар;

12.1.6.индексийн мэдээлэл нийтлэгдэх болон нөхөн төлбөр олгох хугацаа;

12.1.7.индексийн мэдээлэл, тооцоололтой холбоотой гомдол, маргаан шийдвэрлэх нөхцөл;

12.1.8. талбайд байршуулсан мэдрэгч төхөөрөмжийн мэдээллийг ашиглах бол түүнд тавих шаардлага.

13 дугаар зүйл.Суурь зөрүү болон мэдээллийн үүрэг

13.1.Даатгагч гэрээ байгуулахаас өмнө даатгуулагчид суурь зөрүүний утга, үүсэх шалтгаан, болзошгүй үр дагавар, түүнийг бууруулах боломж болон бодит хохирол учирсан боловч нөхөн төлбөр олгогдохгүй байж болох нөхцөлийг энгийн, ойлгомжтой хэлбэрээр бичгээр, эсхүл цахимаар тайлбарлаж, танилцуулсан тухай баталгаажуулна.

13.2.Суурь зөрүүг бууруулах зорилгоор даатгалын нэгжийг нарийвчлах, төлөөлөх чадвар бүхий индекс сонгох, олон индекс хослуулах болон бусад актуар үндэслэлтэй арга хэрэглэж болно.

13.3.Сумын дундаж болон бүсийн ургацын индекс ашиглах тохиолдолд тухайн индекс нь даатгалын нэгжийн ургацын хэлбэлзлийг төлөөлөх статистик хамаарал, өгөгдлийн хүрэлцээтэй байдлыг урьдчилан үнэлсэн байна.

14 дүгээр зүйл.Нөхөн төлбөр олгох

14.1.Индексийн албан ёсны мэдээлэл нийтэд зарлагдаж, даатгалын тохиолдол үүссэн нь тогтоогдсон өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор даатгагч нөхөн төлбөрийг даатгуулагчид олгоно.

14.2.Нөхөн төлбөрийг индексийн албан ёсны мэдээлэл болон гэрээний салшгүй хэсэг болох нөхөн төлбөрийн хүснэгтэд үндэслэн тооцно.

14.3.Индексийн мэдээлэл, тооцооллын талаар маргаан гарсан бол маргаангүй хэсгийн нөхөн төлбөрийг энэ хуулийн 14.1-д заасан хугацаанд олгоно.

14.4.Маргаантай хэсгийн нөхөн төлбөрийг эцсийн дүгнэлт, шийдвэр гарснаас хойш ажлын таван өдрийн дотор олгоно.

15 дугаар зүйл.Даатгуулагчийн эрхийг хамгаалах

15.1.Даатгагч нь даатгуулагчид дараах мэдээллийг энгийн, ойлгомжтой хэлбэрээр урьдчилан хүргэнэ:

15.1.1.индексийн утга, тооцооллын аргачлал;
15.1.2.болзошгүй суурь зөрүүгийн эрсдэл;
15.1.3.нөхөн төлбөр олгогдох болон олгогдохгүй нөхцөл.

15.2.Даатгагч нь даатгалын бүтээгдэхүүний үндсэн нөхцөл, эрсдэл, нөхөн төлбөрийн зарчим зэрэг суурь мэдээллийг товч, ойлгомжтой хэлбэрээр нэгтгэн харуулсан даатгалын бүтээгдэхүүний товч танилцуулгыг даатгуулагчид заавал хүргүүлнэ.

15.3.Даатгуулагчид шаардлагатай санхүүгийн боловсрол олгох сургалтыг холбогдох төрийн байгууллага, даатгагч хамтран зохион байгуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ
ЭРСДЭЛИЙН ХУВААРИЛАЛТ, ДАВХАР ДААТГАЛ, САНГУУД

16 дугаар зүйл.Эрсдэлийн хуваарилалт

16.1.Эрсдэлийг дараах байдлаар хуваарилна:

16.1.1.доод түвшний эрсдэл – даатгуулагч өөрийн хөрөнгөөр хариуцах;
16.1.2.дунд түвшний эрсдэл – даатгагчийн эрсдэлийн дунд түвшний сангаас;
16.1.3.дээд түвшний эрсдэл – эрсдэлийн дээд түвшний сан болон давхар даатгалаар.

17 дугаар зүйл.Хамтын эрсдэлийн сан

17.1.Хамтын эрсдэлийн сан нь давхар даатгалын компанийн дэргэд тусдаа бүртгэлтэй, бие даасан данстай байна.

17.2.Хамтын эрсдэлийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, санхүүжүүлэх, зарцуулах журмыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Санхүүгийн зохицуулах хороо хамтран батална.

17.3.Хамтын эрсдэлийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг Санхүүгийн зохицуулах хороо жил бүр тогтооно.

18 дугаар зүйл.Давхар даатгалын компани, олон улсын давхар даатгал

18.1.Тариалангийн индексжүүлсэн даатгалын дээд түвшний эрсдэлийн давхар даатгал, олон улсын давхар даатгалтай холбоотой үйл ажиллагааг Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 18.1-д заасан давхар даатгалын компани хэрэгжүүлнэ.

19 дүгээр зүйл.Давхар даатгалын компанийн сан

19.1.Тариалангийн индексжүүлсэн даатгалын дунд болон дээд түвшний эрсдэлийг санхүүжүүлэхэд Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 25–27 дугаар зүйлд заасан сангийн тогтолцоог ашиглах бөгөөд тариалангийн индексжүүлсэн даатгалд хамаарах хөрөнгө, орлого, зарлага, өр төлбөрийг тусад нь бүртгэж, тайлагнана.

19.2.Эдгээр санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах журмыг Санхүүгийн зохицуулах хороо төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

20 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөл

20.1.Давхар даатгалын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд санхүү, газар тариалан, статистик, онцгой байдал, цаг уурын өгөгдлийн байгууллага, даатгагч, даатгуулагчийн төлөөллийг оруулна.

20.2.Төлөөлөн удирдах зөвлөл нь дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

20.2.1.бүтээгдэхүүний актуар тооцоолол, техникийн судалгаанд зөвлөмж гаргах;

20.2.2.сангуудын хөрөнгийг удирдах, захиран зарцуулах шийдвэр гаргах;

20.2.3.гэрээний загварыг батлах;

20.2.4.шаардлагатай тохиолдолд даатгагчид хяналт шалгалт хийлгэх хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороонд тавих.

21 дүгээр зүйл.Нууцлал, мэдээллийн хамгаалалт

21.1.Албан үүргийнхээ дагуу олж мэдсэн нууцын зэрэглэлтэй баримт, мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.

22 дугаар зүйл.Тайлан, аудит, нийтэд мэдээлэх

22.1.Давхар даатгалын компанийн санхүүгийн тайланд аудит хийлгэнэ.

22.2.Жилийн тайлан, аудитын дүгнэлтийг нийтэд мэдээлнэ.

22.3.Олон улсын сайн туршлагад нийцүүлэн тодорхой хугацаанд олон улсын нэр хүнд бүхий байгууллагаар давтан аудит хийлгэж болно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ
ТӨРИЙН ДЭМЖЛЭГ, ОРОЛЦОО

23 дугаар зүйл.Төрийн дэмжлэг, татаас

23.1.Төрөөс тариалангийн индексжүүлсэн даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тухайн жилийн батлагдсан улсын төсөв, төсвийн боломжид багтаан даатгалын хураамжийн тодорхой хэсэгт дэмжлэг үзүүлж болно.

23.2.Энэ хуулийн 23.1-д заасан дэмжлэгийн зорилтот бүлэг, шалгуур, хувь хэмжээ, дээд хязгаар болон олгох нөхцөлийг Засгийн газар тогтооно.

23.3.Дэмжлэгийг хэрэгжүүлэхдээ тэгш хүртээмж, ил тод байдал, төсвийн сахилга бат, үр ашигтай байдлын зарчмыг баримтална.

24 дүгээр зүйл.Өгөгдөл, дэд бүтцийн дэмжлэг

24.1.Төрийн холбогдох байгууллага хуульд заасан чиг үүрэг, батлагдсан төсвийн хүрээнд индекс тооцоход шаардлагатай цаг уурын ажиглалт, ургацын статистик, зайнаас тандан судлал, газарзүйн мэдээлэл болон бусад мэдээллийн дэд бүтцийн чанар, хүртээмж, харилцан ажиллагааг сайжруулах арга хэмжээ хэрэгжүүлнэ.

24.2.Индексийн мэдээллийг хэмжих, цуглуулах, боловсруулах, тайлагнах, баталгаажуулах тогтолцоог төрийн холбогдох байгууллага өөрийн чиг үүргийн хүрээнд бүрдүүлж, мэдээлэл солилцох нөхцөлийг хангана.

ДОЛООДУГААР БҮЛЭГ
ХЯНАЛТ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ, ХАРИУЦЛАГА

25 дугаар зүйл.Хяналт тавих

25.1.Энэ хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг Санхүүгийн зохицуулах хороо, холбогдох шатны Засаг дарга, давхар даатгалын компанийн удирдлага эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ.

26 дугаар зүйл.Гомдол, маргаан шийдвэрлэх

26.1.Энэ хуулиар зохицуулаагүй даатгалын гэрээ, үйлчилгээ, гомдол, маргаан шийдвэрлэхтэй холбоотой харилцааг Даатгалын тухай хууль, Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

26.2.Индексийн мэдээлэл, тооцоололтой холбоотой маргааныг хянан шийдвэрлэхэд ашиглах хараат бус шинжээчийг сонгох, түүнд тавих шаардлага, дүгнэлт гаргах хугацаа, талуудын оролцоо болон зардлыг хариуцах журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.

27 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

27.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

27.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ

28 дугаар зүйл.Шилжилтийн үе шатны зохицуулалт

28.1.Энэ хуулийн хэрэгжилтийг хангахдаа дараах үе шат, зарчмыг баримтална:

28.1.1.туршилтын аймаг, суманд хэрэгжүүлэх;

28.1.2.эхний ээлжид эрсдэлийн үнэлгээ, өгөгдлийн бэлэн байдал хангагдсан таримал, индексийн төрлөөр хэрэгжүүлж, улмаар таримлын нэр төрөл болон индексийн төрлийг үе шаттайгаар өргөжүүлэх.

28.2.Туршилтын хэрэгжилтийн үр дүнг үнэлэх гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлттэй байна.

28.3.Туршилтын хугацааны хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг энэ хуулийн 28.2 дахь хэсэгт заасан шалгуураар үнэлж, үнэлгээний дүнд үндэслэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.

28.4.Энэ хуулийн 6.7, 8.4, 11.2, 17.2, 19.2, 26.2-т заасан журмыг энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш зургаан сарын дотор батална.

29 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

29.1.Энэ хууль 2026 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.5.Малын индексжүүлсэн даатгалын болон тариалангийн индексжүүлсэн даатгалын харилцааг тус тусын хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалт:

“3.1.8.Малын индексжүүлсэн даатгалын тухай болон Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасан даатгалын үйл ажиллагаа;”

2/6 дугаар зүйлийн 6.2.7 дахь заалт:

“6.2.7.малын болон тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааны чиглэлээр холбогдох хуульд заасан.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг:

"3.4.Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн давхар даатгалын компани, хамтын эрсдэлийн сан болон давхар даатгалын компанийн сантай холбоотой зохицуулалтыг тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаанд нэгэн адил хэрэглэж болно."

2/18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг:

"18.3.Давхар даатгалын компани Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасан дээд түвшний эрсдэлийн давхар даатгал болон олон улсын давхар даатгалын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ."

3/26 дугаар зүйлийн 26.5 дахь хэсэг:

"26.5.Хамтын эрсдэлийн санг Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасан дунд түвшний эрсдэлийг санхүүжүүлэхэд ашиглаж болох бөгөөд тариалангийн индексжүүлсэн даатгалд хамаарах хөрөнгө, орлого, зарлага, өр төлбөрийг малын индексжүүлсэн даатгалын хөрөнгө, орлого, зарлага, өр төлбөрөөс тусад нь бүртгэж, тайлагнана."

4/27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсэг:

"27.4.Энэ зүйлийн 27.1-д заасан сангийн хөрөнгийг Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасан дунд болон дээд түвшний эрсдэлийг санхүүжүүлэхэд ашиглаж болох бөгөөд тариалангийн индексжүүлсэн даатгалд хамаарах хөрөнгө, орлого, зарлага, өр төлбөрийг тусад нь бүртгэж, тайлагнана."

2 дугаар зүйл.Энэ хуулийг Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Тариалангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“19.10.Тариалангийн индексжүүлсэн даатгалтай холбогдсон харилцааг Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг